



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНГИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С. Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор : Г.Юра
Утас: 263813
Цахим хаяг:
yura@audit.gov.mn

Аудитор : П.Чанцалдулам
Утас: 261740
Цахим хаяг:
chantsaldulamp@audit.gov.mn

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс

Цахим хуудас: www.audit.mn

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Менежментийн захидал
Хавсралт 3: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2014 оны 5 дугаар сар

Оршил

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг Сангийн яамны удирдлагад танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн дотоод хяналтын сул тал, үүсэх эрсдэл, хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Сангийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 2, тусгай сан 4, төслийн 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд 97.3 хувь нь аудитад хамрагдсан байна.

Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны төслийн нэгжийн 2013 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд “Далайван Аудит” ХХК, Тогтвортой амьжиргаа-2 төслийн санхүүгийн тайланд “Улаанбаатар Аудит” ХХК, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн нэгжийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар тус тус аудит хийж, бусад 6 төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийгдээгүйгээр Сангийн сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2013 оны санхүүгийн тайлангуудыг аудитын явцад түүвэрт хамруулсан бөгөөд одоогоор Үндэсний аудитын газраас Төрийн сангийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийж байна.

Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Сангийн яамны аппарат, Төсвийн тогтворжуулалтын сан, Засгийн газрын нөөц сан болон төслийн 3 нэгжийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Сангийн сайд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр Сангийн сайдын баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Нэг. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар.

1. Сангийн яамны аппарат:

- “Хөх монгол принтинг” ХХК-иар “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цолны тэмдэг 5000 ширхэгийг хийлгүүлэхээр 2012 оны 12 дугаар

сарын 27-ны өдөр “Хэвлэлийн ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан тус компанид 25.0 сая төгрөг шилжүүлсэн боловч 2013 оны туршид тэмдгийн загварыг шалгаруулж чадаагүй гэдэг шалтгаанаар авлагаар бүртгэж тайлагнасан,

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.2.1 дүгээр заалтад “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ гэж заасны зөрчиж тус яамны 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 138.4 сая төгрөгийн хангамжийн бараа материалыг үлдэгдлээр бүртгэж тайлагнасан боловч тооллого хийгээгүй байна.

2. Гаалийн ерөнхий газар:

- 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй, өглөг, авлагын тооцоо нийлж акт үйлдээгүй, түлш халаалтын зардлын бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, хэрэгцээг зөв тооцоолоогүй, бараа материалын дансаар дамжуулаагүй зэрэг шалтгааны улмаас Завхан аймгийн Арцсуурь Гаалийн хорооны санхүүгийн тайланд “хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн,
- ГЕГ-ын дүнгээр 2013 онд батлагдсан төсвөөс тээвэр шатахууны зардал 24.9 сая, бичиг хэргийн зардал 7.7 сая, гадаад томилолт 2.5 сая, урсгал засварын зардал 9.5 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 29.1 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн,
- "Төлбөр хураамж бусад зардал" дүнгээрээ хэтрээгүй боловч энэ ангиллаар 108.9 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлс худалдан авсны дотор нэг бүр нь 2.2 сая төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг кофе чанагч авахад 8.8 сая төгрөг зарцуулсан,
- 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн "дуусаагүй барилга" дансанд тайлагнагдсан 2008-2013 онд ашиглалтад орсон нийт 9,888.7 сая төгрөгийн өртөг бүхий барилга байгууламжийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгээгүйгээс элэгдлийн зардал тооцогдохгүй, санхүүгийн үр дүнг илүү дүнгээр буруу илэрхийлсэн,
- ГЕГ-ын хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн өглөгийн бүртгэл, уг хөрөнгийг байршуулж буй Төрийн сангийн харилцахын үлдэгдлээс зөрүүтэй байна. Энэ нь 2008 онд Ховд аймгийн Ярант боомтын Шалган нэвтрүүлэх цэгийн барилгын гүйцэтгэгч Мон Инж Бар ХХК-д 24.3 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосноос авлага үүссэн, улмаар 2011 онд тус компаниас 15.0 сая төрөг буцаан авч, үлдэгдэл 9.3 сая төгрөг өнөөг хүртэл төлөгдөөгүй байна.

Гаалийн ерөнхий газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 546.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 156.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 43.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 340.1 сая төгрөгийн залруулга хийсэн байна.

3. Татварын ерөнхий газар:

Татварын ерөнхий газрын төсвийн багцад хамрагддаг нийт 32 хэлтэс, газрын 2013 оны санхүүгийн тайланд аудит хийснээс Үндэсний аудитын газар Улсын төсвийн орлого хяналтын газар, ТЕГ-ын аппарат болон санхүүгийн нэгтгэсэн тайланд, аймаг,

нийслэл, дүүргийн татварын 30 хэлтсийн санхүүгийн тайланд аймаг, нийслэлийн Аудитын газрууд аудит хийж “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

- Тайлант онд ТЕГ-ын дүнгээр авлага өмнөх оноос 79.6 хувиар буюу 799.8 сая төгрөг /үүнээс ажиллагчидтай холбоотой авлага 12.2 сая, байгууллагаас авах авлага 787.6 сая төгрөг/-өөр, нийт өр төлбөр 2013 оны эхэнд 138.7 сая төгрөг байсан бол оны эцэст 266.0 сая төгрөг болж, оны эхнээс 127.3 сая төгрөг буюу 91.8 хувиар өссөн,
- Улсын татварын орлого хяналтын газар Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тооцоолсон, санхүүгийн тооцоолох програмын алдаа зэргээс шалтгаалан элэгдлийн зардлыг 12.9 сая төгрөгийн дутуу дүнгээр бүртгэж тайлагнасан,
- Санхүүгийн тооцоолох програмын алдаанаас шалтгаалан ТЕГ-ын аппаратын 2013 оны мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлд үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 3,359.2 сая, бараа үйлчилгээний урсгал зардлын дүн 1.2 сая төгрөгөөр, УТОХГ-ын мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлд үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 5.5 сая, үйл ажиллагааны мөнгөн зардлын дүн 73.0 сая төгрөгөөр тус тус 2012 оны аудит хийгдсэн тайлангийн дүнгээс зөрүүтэй тайлагнагдсаныг аудитын явцад залруулсан.

Татварын ерөнхий газар, аймаг, орон нутгийн Татварын албадын санхүүгийн тайлангийн аудитаар 333.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 29.3 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах 14 зөвлөмж өгөгдөж, 2.6 сая төгрөгийг төсвийн орлого болгох төлбөрийн 3 акт тогтоож, 6.5 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоохоор 2 албан шаардлага өгсөн байна.

Хоёр. Сангийн сайдын төсвийн багцын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Засгийн газрын тусгай санд хийсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар.

1. Засгийн газрын нөөц сан:

- Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2013 оны төсвийн багцад Засгийн газрын нөөц сангийн зардалд 20.0 тэрбум төгрөг зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр 16,309.8 сая төгрөгийг зарцуулан тайлагнажээ.
- Засгийн газрын нөөц сангаас 2013 онд зарцуулсан хөрөнгийн 46.1 хувийг цаг үеийн ажил, байгалийн бэрхшээлийн зардал, 14.8 хувийг хөрөнгө оруулалтын зардал, 23.9 хувийг төрийн өмнөөс үзүүлэх ажил үйлчилгээ /нууц/, 1.6 хувийг хурал зөвлөгөөний зардал, 13.6 хувийг ойн арга хэмжээ, баяр ёслол, шагнал урамшууллын зардал эзэлж байна.
- Засгийн газрын нөөц сангийн 2013 оны санхүүгийн тайланд байгууллагаас авах авлага 629.8 сая төгрөгөөр тайлагнагдсан, үүнээс 20.6 сая төгрөг нь 2014 онд үргэлжлэн санхүүжигдэх төсөл арга хэмжээний авлага, 609.2 сая төгрөг нь Засгийн газрын тогтоолын хэмнэлт бөгөөд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.2.3-д заасны дагуу аудитаар дээрх

авлагыг барагдуулж Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон болно.

2. Төсвийн тогтворжуулалтын сан:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.2.1-д заасны дагуу УИХ-аас баталсан Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2013 оны төсвийн багцад Төсвийн тогтворжуулалтын санд 48,965.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1,219.3 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар тасарсан бөгөөд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.6.1-д заасны дагуу сангийн нийт орлогын 383,451.7 сая төгрөгийг Монголбанкн дах Төрийн сангийн харилцах дансанд байршуулсан байна.
- Төсвийн тогтворжуулалтын санд 2013 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 48,965.2 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч 2,106.6 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь уул уурхайн голлох нэрийн бүтээгдэхүүн болох зэсийн зах зээлийн дундаж үнэ 7.389.00 ам.доллар болж, төлөвлөснөөс 10 ам.доллараар буурсантай холбоотой байна.

3. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан:

- Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тус сангаас олгосон хүүгийн урамшууллын зарцуулагдаагүй үлдэгдэл нийт 478.8 сая төгрөг, үүнээс Төрийн банкинд 49.2 сая төгрөг, Капитрон банкинд 424.7 сая төгрөг, Хас банкинд 4.9 сая төгрөг байршиж байгааг авлагаар бүртгэж тайлагнасан,
- Төрийн банк нэр бүхий 6 зээлдэгчийн зээлийн хүүгийн нийт 5.5 сая төгрөгийг тус сангаас олгосон хүүгийн урамшууллын эх үүсвэрийн хэмжээнээс хэтрүүлэн хасагдуулга хийсэн байна.

Аудитаар дээр дурдсан нийт 484.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоогдсон болно.

4. Монгол Улсыг хөгжүүлэх сан:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болсон Монгол Улсыг хөгжүүлэх сан /МУХС/-гийн санхүүгийн тайланд 31,657.9 сая төгрөгийг үрийн буудайн авлагаар, 5,766.7 сая төгрөгийг нөөцөд байгаа шатахууны үлдэгдлээр тус тус бүртгэж тайлагнасан.
- МУХС-гийн 2013 оны санхүүгийн тайланд Тариалан эрхлэлтийг дэмжих сан /ТЭДС/-гаас авах улаан буудайн авлагыг 2012 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн “Гэрээ дүгнэсэн акт”-ыг үндэслэн 29,115.5 сая төгрөгөөр тайлагнасан бол ТЭДС-гийн тайлангаар МУХС-д өгөх өглөгийг 27,311.1 сая төгрөг буюу 1,804.4 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. Энэ нь ТЭДС 2012 онд хадгалагдаж байгаа улаан буудайн хадгалалтын зардал, хэвийн хорогдлын хасагдуулгыг тооцон бүртгэсэнтэй холбоотой байна.

- Үндэсний аудитын газраас Сангийн сайдын төсвийн багцын 2011 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар МУХС-д үлдэгдэлтэй 37,283.1 сая төгрөгийн улаан буудайг тогтоосон үнээр худалдан борлуулж, төрийн санд төвлөрүүлэн, төсвийн орлого болгохоор акт тогтоож, бодитоор байхгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, үнийн зөрүүгийн алдагдал гэсэн тайлбартай шатахууны үлдэгдлийн 5,766.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах асуудлыг ХХААХҮЯ, Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудад хариуцуулан улмаар эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулах албан шаардлагыг Үндэсний аудитын газрын 2012 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 01/25 албан бичгээр хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл биелэгдээгүй,
- Түүнчлэн Засгийн газрын 2012 оны 77 дугаар тогтоолын 3 дугаар заалтад “УИХ-ын 2008 оны 42 дугаар тогтоолын дагуу МУХС-д нөөц хэлбэрээр байршуулсан 80.8 мянган тонн хүнсний буудайн борлуулалт, үүссэн өр авлагатай холбоотой асуудлыг судалж, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, ҮХАА-н сайд Х.Баттулга, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай” гэж заасныг хэрэгжүүлээгүй, холбогдох арга хэмжээг аваагүй байна.

Гурав. Сангийн сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайлагналын талаар.

- Өмнөх оноос авлага нийт дүнгээр 1,080.6 сая төгрөгөөр буурсан хэдий ч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээлийн авлага 14,657.0 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 624.3 сая төгрөгөөр өссөн байна.
- Сангийн сайдын төсвийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 201.4 сая төгрөгөөр буурсан боловч, сайдын багцад хэрэгжиж буй гадаад төслүүдийн зээлийн ашиглалттай холбоотойгоор урт хугацаат өр төлбөр 65,794.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- “Тогтвортой амжиргаа-2 төсөл”, “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-үүдийн тайлант оны элэгдлийн зардал нийт 250.5 сая төгрөгөөр дутуу тайлагнагдсаныг аудитын явцад Сангийн сайдын төсвийн багцын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.
- Гаалийн ерөнхий газар 4,819.7 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн 2,989.7 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн хуримтлагдсан элэгдлийн хасагдах хэсэгт данснаас хасалтаар бүртгэсэн байсныг аудитын явцад залруулсан болно.
- Сангийн сайдын төсвийн багцад 9 төсөл хөтөлбөрийн нийт 21,222.5 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтын тайлан нэгтгэгдсэнээс 3 төсөл хөтөлбөрийн 11,152.1 сая төгрөгийн санхүүжилттэй тайланг аудитаар баталгаажуулж, 6 төсөл хөтөлбөрийн нийт 10,070.4 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлд аудит хийгдэлгүйгээр нэгтгэгдсэн байна.

Сангийн сайдын төсвийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 6,610.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 3 зөвлөмж өгч, 1,093.5 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах 2 акт тогтоогдсон болно.

Дөрөв. Сангийн сайдын 2013 оны төсвийн хэрэгжилтийн талаар.

Сангийн сайдын төсвийн 2013 оны нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээ 52.0 тэрбум төгрөгийн хэмнэлттэй гарсан. Зардлын бүлгээр авч үзвэл урсгал зардал 81.1 тэрбум төгрөг буюу 10.4 хувь, хөрөнгийн зардал 6.7 тэрбум төгрөг буюу 47.9 хувийн хэмнэлттэй гарч эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээлийн дүн 36.0 тэрбум төгрөгөөр хэтэрч гарсан дүнтэй байна.

Нийт зарлага санхүүжилтийн 94.2 хувийг төсвөөс, 4.7 хувийг гадаад төслийн зээлээс, 0.5 хувийг туслах үйл ажиллагааны орлогоос, 0.6 хувийг оны эхний үлдэгдлээс тус тус санхүүжүүлжээ.

Бараа үйлчилгээний зардал 14.2 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэнийг бүтцийн хувьд ангилж үзвэл, цалин хөлс 0.8 тэрбум, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.2 тэрбум, бараа үйлчилгээний урсгал зардал 13.3 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан Сангийн сайдын багцын төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй ажиллах, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Сангийн сайдаас “Төсвийн зардлыг хэмнэх зарим арга хэмжээний тухай” 2013 оны 239 дүгээр тушаалыг батлан, хэрэгжүүлж ажиллах талаар яамны ТНБДарга болон болон харьяа агентлагуудын удирдлагуудад чиглэл өгч ажиллуулжээ. Үүнд:

- Тээвэр шатахуун, шуудан холбоо, бичиг хэрэг, урсгал засварын зардлыг 10-аас доошгүй хувиар хэмнэх горимд шилжих,
- Төв, суурин газрын төсвийн байгууллагуудад халаалтын хэмнэлтийн горим сонгох, цахилгаан, усыг хэмнэж, ариг гамтай зарцуулах,
- Гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардлыг хэтрүүлэхгүй ажиллахыг үүрэг болгожээ.

Сангийн яам болон харьяа агентлагууд тушаалын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч батлагдсан төсвийг нийт дүнгээр 52.0 тэрбум төгрөг буюу 6.4 хувиар хэмнэлттэй зарцуулсан байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сангийн сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. */Зөвлөмжийн биелэлтийг хавсаргав/*

Аудитын санал дүгнэлт

Бид Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор өмнөх шатанд хийсэн аудитын дүнг үнэлж, нэгтгэх, аудитын түүвэрт хамрагдсан зарим байгууллагын харилцахын болон бусад анхан шатны баримтыг дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлангийн зохих үзүүлэлтүүдтэй тулган шалгав.

2013 оны нийт зардлын гүйцэтгэлийг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгож, аудитын явцад тооцсон эрсдэлийг харгалзан материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцсон болно.

Бид Сангийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд Монгол Улсад мөрдөж байгаа стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна гэж үзэж “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

САНГИЙН САЙД Ч.УЛААН ТАНАА

2014.05.05 № 726

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Сангийн яамны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сангийн сайдын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А. ЗАНГАД

070521
Тамгын газрын А-5бланк

Сангийн сайдын төсвийн багцын 2012 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

д/д	АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ	ӨГСӨН ЗӨВЛӨМЖ	БИЕЛЭЛТ	%
1	<p>“Сансрын хиймэл дагуулаар телевизийн 10 сувгийн нэвтрүүлэг орон даяар дамжуулах үйлчилгээний төлбөрийн гэрээ”-г Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, Жем Интернэшнл ХХК-тай 10 жилийн хугацаатай, жил бүр 1.2 сая ам доллар төлөхөөр байгуулжээ.</p> <p>Гэвч дээрх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлсний үндсэн дээр төлбөр гүйцэтгэх талаар тодорхой тусгаагүйгээс гадна гэрээний дагуу Засгийн газар орон даяар дамжуулах 10 сувгийн нэрийг тогтоож өгөөгүй байна.</p>	<p>Засгийн газар Жем Интернэшнл ХХК-тай байгуулсан “Сансрын хиймэл дагуулаар телевизийн 10 сувгийн нэвтрүүлэг орон даяар дамжуулах үйлчилгээний төлбөрийн гэрээ”-ний биелэлтийг дүгнэх;</p> <p>Цаашид хэрэгжилтийг үнэлсэн эрх бүхий мэргэжлийн байгууллагын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлэх зарчмыг баримтлах талаар гэрээнд өөрчлөлт оруулах;</p> <p>Засгийн газар орон даяар дамжуулах 10 сувгийн нэрсийг тодорхойлж өгөх;</p> <p>Дотоод хяналтыг сайжруулах;</p>	<p>Сангийн сайдын төсвийн багцад тусгагдаж байсан 10 сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах зардлыг 2014 оны төсвийн жилээс эхлэн Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газарт шилжүүлж, Сангийн сайдын төсвийн багцаас хассан байна.</p>	100.0
2	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг зөрчин төлбөр хураамжийн зардлаас 857.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн төлбөр хураамжийн зардлаар бүртгэсэн байна.</p> <p>Гадаад зээлийн ашиглалтын төлөвлөлтөөс шалтгаалан батлагдсан төсвийг 15,045.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Нотлох баримтгүйгээр 5,376,858.0 ам.доллартай тэнцэх бондын эх үүсвэрийг хүүгийн зардлаар бүртгэсэн байна.</p> <p>Урьд оны өр барагдуулах зардлаас 2012 онд үүссэн өрийг барагдуулахаар Баянхонгор аймгийн ЗДТГ-т 259.0 сая төгрөг, Эрүүл мэндийн яаманд 349.6 сая төгрөг, Сүхбаатар аймагт 200.0 сая төгрөг, Өвөрхангай аймагт 70.0 сая төгрөг тус тус олгосон байна,</p> <p>Сангийн сайдын багцын нийт 5.5 тэрбум төгрөгийн зардлыг тус яамны аппаратын зардалд төлөвлөж санхүүжүүлсэн байна.</p>	<p>Урсгал зардлаас хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхгүй байх;</p> <p>Төсвийн төлөвлөлтийн үндэслэл, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах;</p> <p>НББ-ийн тухай болон холбогдох хуулийг мөрдөж ажиллах;</p> <p>Сангийн сайдын 2005 оны 276 дугаар тушаалаар батлагдсан дансны жагсаалтыг мөрдөж ажиллах;</p>	<p>2013 оны төсвийн жилээс эхлэн төлбөр хураамжийн зардлаас хөрөнгө бэлтгэх асуудлыг бүрэн зогсоосон.</p> <p>Зээл тусламжийн бодлогын газраас 2012 онд Сангийн яаманд хэрэгжиж буй нэр бүхий 9 төслийн гадаад зээлийн ашиглалтын зардлыг Сангийн сайдын багцад 75.0 тэрбум төгрөг байхаар төлөвлөж оруулсныг 33.5 тэрбум төгрөгөөр хянан батлуулсан нь 2012 оны төсөвт зардал нийт дүнгээр 15.0 тэрбум төгрөгөөр хэтрэхэд нөлөөлсөн. 2013 оны батлагдсан төсөвт зардлыг нийт дүнгээр 6.4 хувиар буюу 51.7 тэрбум төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан.</p> <p>СБӨУГ-ын нээсэн эрхийн дагуу 5,376.9 мянган ам.долларыг үнэт цаасны гарсан зардлын нөхөн санхүүжилтэд санхүүжүүлж, уг төлбөрөөс 379.3 мянган ам.доллар буюу 545.0 сая төгрөг буцаж улсын төсвийн 3332400 дугаар дансанд эргэн төвлөрсөн.</p>	100.0

			<p>“Өр барагдуулах тухай” Сангийн сайдын 2012 оны 263, 284, 288 дугаар тушаалаар тухайн санхүүжилтийг олгосон. Мөн тушаалаар ТЕЗ-дыг цаашид өр төлбөр үүсгэхгүй байхад онцгой анхаарч ажиллахыг даалгаж, тушаалын биелэлтэд хяналт тавих үүргийг яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, Төрийн сангийн газарт үүрэг болгосноор 2013 онд шинээр үүсэх өрийг бууруулсан.</p> <p>“Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх журам”-ыг Сангийн сайдын 2013 оны 230 дугаар тушаалаар батлуулж, сайдын багцын төсөл арга хэмжээний зардлыг яамны урсгал зардлын гүйцэтгэлд оруулахгүйгээр тусд нь тайлагнаж байхаар болсон байна.</p>
--	--	--	--



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗА

САНГИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1

Авлагын талаар

Асуудал 2

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын талаар

Асуудал 3

Санхүүгийн тайлагналын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг. Түүнд дотоод хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Сангийн яамны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа, ахлах мэргэжилтэн Н.Мөнхсүх болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

Асуудал 1. Авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Өмнөх оноос авлага нийт дүнгээр 1,080.6 сая төгрөгөөр буурсан хэдий ч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээлийн авлага 14,657.0 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 624.3 сая төгрөгөөр өссөн.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болсон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд 31,657.9 сая төгрөгийг үрийн буудайн авлагаар, 5,766.7 сая төгрөгийг нөөцөд байгаа шатахууны үлдэгдлээр тус тус бүртгэж тайлагнасан. Үүнээс үрийн буудайн авлагын 29,115.5 сая төгрөг, нөөцийн шатахууны 5,766.7 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд нийт авлагын дүн үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх;

Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх;

ҮАГ-ын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19.1.4-д заасныг хэрэгжүүлж, 2014 онд авлага барагдуулах, данснаас хасалт хийх талаар тодорхой ажил зохион байгуулах. Тайлант хугацааны эцэст авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах арга хэмжээ авч ажиллах;

Засгийн газрын 2012 оны 77 дугаар тогтоолын 3 дугаар заалт, Сангийн сайдын төсвийн багцын 2011 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар МУХС-ийн тайланд тусгагдсан авлага, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

ҮАГ-ын ажиглалт

“Тогтвортой амжиргаа-2 төсөл”, “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-үүдийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд тайлант оны элэгдлийн зардал нь нийт 250.5 сая төгрөгөөр санхүүгийн үр дүнгийн тайлангийн элэгдлийн зардлаас дутуу тайлагнагдсаныг Сангийн сайдын төсвийн багцын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад залруулсан.

Гаалийн ерөнхий газар 4,819.7 сая төгрөгийн өртөгтэй, 2,989.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэхдээ шилжиж ирсэн хуримтлагдсан элэгдлийн дүнг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн хуримтлагдсан элэгдлийн хасагдах хэсэгт данснаас хасалтаар бүртгэсэн байсныг аудитын явцад залруулсан.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдэхгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын төсвийн багцад хамрагддаг төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланг аудитад бүрэн хамруулж, баталгаажуулах арга хэмжээ авч, аудит хийгдсэн тайланг нэгтгэлд хамруулж байх;

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийгдсэн эсэхээс үл хамааран тайлангийн үзүүлэлтүүд хоорондын тохиргоог нарийвчлан шалган хүлээн авч нэгтгэлд хамруулж байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

ҮАГ-ын ажиглалт

Сангийн сайдын төсвийн багцад 9 төсөл хөтөлбөрийн нийт 21,222.5 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтын тайлан нэгтгэгдсэнээс 3 төсөл хөтөлбөрийн 11,152.1 сая төгрөгийн санхүүжилттэй тайланг аудитаар баталгаажуулж, 6 төсөл хөтөлбөрийн нийт 10,070.4 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлд аудит хийгдэлгүйгээр нэгтгэгдсэн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдэхгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын төсвийн багцад хамрагддаг төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланг аудитад бүрэн хамруулж, баталгаажуулах арга хэмжээ авч, аудит хийгдсэн тайланг нэгтгэлд хамруулж байх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,352,122,649.95	408,718,930,392.18
Кассанд байгаа бэлэн мөнгө	6,722,473.57	3,812,486,242.18
Төгрөг\ ЖМС	6,722,473.57	16,215,842.47
Гадаад валют	-	3,796,270,399.71
Банкинд байгаа бэлэн мөнгө	21,345,400,176.38	404,904,135,150.00
Төгрөг	12,342,256,866.65	397,384,030,874.61
Улсын төсвийн харилцах	82,699,543.36	-
Төсөвт байгууллын харилцах (Төрийн сан)	4,202,392,071.16	7,571,895,744.64
Төсөвт байгууллагын харилцах	5,398,679,898.91	2,740,901,069.02
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	2,658,485,353.22	386,684,246,844.13
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	386,987,216.82
Гадаад валют	9,003,143,309.73	7,520,104,275.39
Бусад төсөл, нөөцийн харилцах	9,003,143,309.73	7,520,104,275.39
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	2,309,000.00
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000,000.00	100,000,000.00
Үнэт цаас	100,000,000.00	100,000,000.00
Төгрөг	100,000,000.00	100,000,000.00
АВЛАГА	125,274,187,335.27	124,193,635,543.14
Ажиллагчидтай холбогдсон авлага	793,814.00	13,014,130.39
Төлбөртэй үйлчилгээний авлага	4,346,041,212.00	4,284,000,000.00
Зээлийн хүүгийн авлага	16,582,574.29	640,927,321.35
Бусад авлага	62,780,484,317.42	46,468,379,388.23
Байгууллагаас авах авлага	62,744,140,614.19	46,435,124,920.54
Гэрэл цахилгааны авлага	-	582,384.00
Бусад зардлын тооцооны авлага	62,744,140,614.19	46,434,542,536.54
Хувь хүмүүсээс авах авлага	36,343,703.23	33,254,467.69
Зээлийн авлага	58,130,285,417.56	72,787,314,703.17
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	58,130,285,417.56	72,787,314,703.17
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	58,130,285,417.56	72,787,314,703.17
УРЬДЧИЛГАА	65,531,594.00	70,150,789.00
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	1,945,348.00	-
Урсгал Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон урьдчилгаа	1,945,348.00	-
Бусад урьдчилгаа	12,357,576.00	-
Бусад урьдчилгаа	51,228,670.00	70,150,789.00
Урьдчилгаа тооцоо	8,555,270.00	70,150,789.00
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	6,141,963.00	4,912,834.00
Томилолтын урьдчилгаа	2,413,307.00	65,237,955.00
Урьдчилж гарсан зардал	42,673,400.00	-
Урьдчилж төлсөн зардал	42,673,400.00	-
БАРАА МАТЕРИАЛ	7,641,838,282.42	7,945,394,152.81
Түүхий эд материал	58,041,488.04	76,034,640.18
Тусгай зориулалттай материал	2,300,556.00	10,475,629.64
Эм боох материал	227,601.50	210,501.50
Бэлэн бүтээгдэхүүн	55,513,330.54	65,348,509.04
Хангамжийн материал	7,489,377,657.20	7,749,825,759.44
Бичиг хэргийн материал	131,354,155.47	165,007,321.07
Аж ахуйн материал	717,213,913.19	728,412,412.00
Сэлбэг хэрэгсэл	28,360,164.00	43,005,815.23
Түлш, шатах тослох материал	96,618,720.15	135,129,425.43
Барилгын засварын материал	7,045,237.95	4,339,672.09
Хүнсний материал	10,652,565.04	4,037,489.00
Баглаа боодол	-	39,400.00
Бусад бараа материал	6,498,132,901.40	6,669,854,224.56
Мал амьтад	82,915,021.18	97,986,070.19
Бусад	11,504,116.00	21,547,683.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	154,433,679,861.64	541,028,110,877.13

ҮНДСЭН ХӨРӨНГӨ	87,951,860,873.24	82,616,814,788.15
Биет хөрөнгө	87,553,097,384.27	80,623,608,629.85
Барилга, байгууламж, орон сууц	55,473,412,345.58	52,614,894,131.61
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	67,662,867,081.13	66,111,782,624.13
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(12,189,454,735.55)	(13,496,888,492.52)
Авто-тээврийн хэрэгсэл	2,729,638,411.36	3,078,094,289.60
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	5,156,503,863.13	6,233,981,816.17
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(2,426,865,451.77)	(3,155,887,526.57)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,839,320,252.53	11,297,245,018.04
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	24,481,162,690.23	27,834,803,115.62
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(13,641,842,437.70)	(16,537,558,097.58)
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,060,436,053.09	2,999,812,846.36
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	5,125,967,083.12	5,370,961,080.33
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(2,065,531,030.03)	(2,371,148,233.97)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,610,750.00	7,610,750.00
Бусад үндсэн хөрөнгө	5,354,107,908.16	440,862,121.69
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	5,561,896,710.74	655,007,638.56
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(260,352,974.48)	(261,609,938.77)
Номын фонд	52,564,171.90	47,464,421.90
Дуусаагүй барилга, байгууламж	10,088,571,663.55	10,185,089,472.55
Биет бус хөрөнгө	398,763,488.97	1,993,206,158.30
Програм хангамж	416,252,920.97	1,874,062,224.66
Програм хангамж - Анхны өртөг	539,822,619.91	5,056,790,755.59
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(123,569,698.94)	(3,182,728,530.93)
Бусад биет бус хөрөнгө	(17,489,432.00)	119,143,933.64
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	830,550.00	121,674,900.30
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(18,319,982.00)	(2,530,966.66)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	242,385,540,734.88	623,644,925,665.28
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,007,550,288.21	1,806,058,300.78
Өглөг	2,007,550,288.21	1,805,423,300.78
Ажилчидтай холбогдсон тооцоо	113,954,780.28	9,564,464.86
Цалингийн өглөг	43,489,903.00	1,665,215.00
НДШ-ийн өглөг	18,754,625.54	1,719,951.18
ХАОАТ-ын өглөг	51,710,251.74	6,179,298.68
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	341,347,443.80	39,836,088.41
Шуудан холбооны тооцоо	34,700.00	-
Байрны түрээсийн тооцоо	(15,534,036.48)	-
Бусад зардлын тооцоо	356,846,780.28	39,836,088.41
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	718,342,636.76	1,486,326,892.91
Бусад өглөг	833,905,427.37	269,695,854.60
Байгууллагад төлөх өглөг	833,625,385.02	269,515,859.25
Хувь хүмүүст төлөх өглөг	280,042.35	179,995.35
Урьдчилж орсон орлого	-	635,000.00
Төсөвт байгууллага	-	635,000.00
Урьдчилж орсон хөрөнгийн орлого	-	635,000.00
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	10,642,414,777.00	76,437,115,652.02
Урт хугацаат үнэт цаас	937,000,000.00	-
Төгрөгөөр	937,000,000.00	-
Урт хугацаат зээл	9,705,414,777.00	76,437,115,652.02
Төгрөгөөр	8,440,772,059.00	-
Санхүүгийн бусад байгууллага	8,440,772,059.00	-
Гадаад валют	1,264,642,718.00	76,437,115,652.02
Олон улсын санхүүгийн байгууллагаас	-	76,437,115,652.02
Төслийн зээл	-	76,437,115,652.02
Бусад гадаад эх үүсвэр	1,264,642,718.00	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	12,649,965,065.21	78,243,173,952.80
Засгийн газрын хувь оролцоо	229,735,575,669.67	545,401,751,712.48
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	80,241,815,693.59	74,513,561,315.26
Хуримтлагдсан үр дүн	141,042,225,922.41	463,131,924,327.19
Өмнөх үеийн үр дүн	141,042,225,922.41	418,730,906,125.73
Тайлант үеийн үр дүн	-	44,401,018,201.46
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,451,534,053.67	7,756,266,070.03
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	229,735,575,669.67	545,401,751,712.48
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	242,385,540,734.88	623,644,925,665.28

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТАТВАРЫН ОРЛОГО	-	46,858,567,678.80
Орлогын албан татвар	-	7,554,384,247.09
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	7,554,384,247.09
Төрийн өмчит аж ахуйн нэгжийн	-	7,554,384,247.09
Бараа, үйлчилгээний албан татвар	-	10,839,210,794.97
Зарим төрлийн барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн татвар	-	10,839,210,794.97
Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	-	10,839,210,794.97
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	10,839,210,794.97
Бусад татвар, төлбөр, хураамж	-	28,464,972,636.74
Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	-	28,464,972,636.74
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,406,809,727.39	377,117,506,451.47
Олон улсын байгууллагын тусламж	10,523,498,091.33	-
Урсгал тусламж	10,523,498,091.33	-
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	304,883,311,636.06	377,117,506,451.47
Улсын төвлөрсөн төсвөөс	258,839,024,643.76	408,803,197,287.92
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	264,091,408,211.10	396,211,797,722.61
Засгийн газрын нөөц хөрөнгө	-	887,408,446.05
Хөрөнгийн	-	4,771,461,746.00
Сангийн сайдын багцаас санхүүжүүлсэн	5,000,000,000.00	4,324,486,748.09
Санхүүгийн зээлээс санхүүжих	(10,252,383,567.34)	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,608,042,625.17
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	2,558,509,625.17
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	220,000.00
Төсвийн урамшуулал	-	49,313,000.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	5,962,982,142.39	77,104,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	455,000,000.00	77,104,000.00
Хөрөнгийн	5,507,982,142.39	-
Төсөвт байгууллагаас	3,895,891,747.03	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,872,076,931.03	-
Хөрөнгийн	23,814,816.00	-
Нийгмийн даатгалын сангаас	46,398,237.00	143,127,394.00
НДС-ийн шилжүүлэг	-	142,851,261.00
ЭМДС-ийн шилжүүлэг	46,398,237.00	276,133.00
